



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬ ТОГТООМЖИД ОРСОН НЭМЭЛТ  
ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ**



### Нэмэлт, өөрчлөлт орсон хууль:

1. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
4. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;



**НЭГ. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ДАГУУ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ЗААЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ**

№	ХУУЛИЙН ЗААЛТ		ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ
	Хуучин	Шинэ	
1	<b>4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:</b>		Цаа буга маллан тайгад амьдарч буй цаатан иргэнийг улсын төсвөөс шимтгэлийг хариуцаж тэтгэврийн болон тэтгэмжийн нийгмийн даатгалд хамруулснаар: <ul style="list-style-type: none"> <li>• өндөр насны тэтгэвэр,</li> <li>• тахир дутуугийн тэтгэвэр,</li> <li>• тэжээгчээ алдсаны тэтгэвэр,</li> <li>• хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж,</li> <li>• жирэмсний болон амаржсаны тэтгэмж,</li> <li>• оршуулгын тэтгэмж</li> </ul> авах эрх үүсч нийгмийн баталгаа нь хангагдах боломжтой болов.
	ШИНЭ ЗААЛТ	“7. Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэнийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан даатгалд төрөөс даатгуулна.”	
2	<b>16 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэг:</b>		
	ШИНЭ ЗААЛТ	“9. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар тооцон улсын төсвөөс жил бүр нийгмийн даатгалын санд төлнө.” “10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох орлогын хэмжээ, шимтгэл төлөх журмыг Засгийн газар батална.”	



3	<b>4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:</b>		
	<p>“1. Өмчийн бүх хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд зааснаар иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;”</p>	<p>“1. Өмчийн бүх хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;”</p>	
4	<b>4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:</b>		<p>Тэтгэвэр авагч нь Ажил олгогч, иргэнтэй хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа бол тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалд хамрагдах боломжтой болов.</p> <p>1-ээс дээш ажил эрхэлж буй даатгуулагч нь 10 хувиар шимтгэл төлж байсныг ажилгүйдлийн даатгалаас бусад 4 төрлийн даатгалд хамрагдаж, даатгуулагч 9.8 хувиар, АО нь 10.8-12.8 хувиар шимтгэл төлөх өөрчлөлт орлоо.</p>
	<p>“6. Ажил олгогч, иргэнтэй хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5-д зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна.</p>	<p>“6. Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна.”</p>	



<b>12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:</b>			
5	<p>2. НДҮЗ нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг тухайн жилийн улсын төсвийн төслийн хамт Засгийн газарт мэдүүлнэ. ЗГ нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг улсын төсвийн төслийн хамт УИХ-д 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор өргөн мэдүүлнэ.</p>	<p>“2. Нийгмийн даатгалын сангийн төсвийг Төсвийн тухай хуулийн 8.4-т заасан цаглабарын дагуу боловсруулж, батална. Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Нийгмийн даатгалын тухай хуульд заасан нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл боловсруулах, батлах, хүргүүлэх цагалбарыг 2013 оноос мөрдөж эхэлсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т нийцүүлэв.</p> <p>(8.4.1.төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;</p> <p>8.4.2.төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;</p> <p>8.4.3.төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>8.4.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн өргөн мэдүүлэх)</p>



**13 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг**

6

1. Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, тайлан тэнцлийг дор дурдсан хугацаанд улирал, жилээр нэгтгэн гаргаж Үндэсний зөвлөлд тайлагнаж байна:

1/ нийгмийн даатгалын сан тус бүрийн орлого, зарлагын тайланг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага улирлын дараа сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагад, аймаг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага тухайн улирлын дараа сарын 25-ны дотор нийгмийн даатгалын төв байгууллагад тус тус ирүүлнэ.

2/ Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 10-ны дотор, жилийн эцсийнхийг дараа оны 2 дугаар сарын 25-ны дотор тус тус нэгтгэн санал дүгнэлтээ Үндэсний зөвлөлд оруулна.

3/ Үндэсний зөвлөл нь улирлын тайланг дараагийн улирлын сүүлийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараагийн жилийн 1 дүгээр улиралд багтааж хянан хэлэлцэнэ.

“1. Сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн улирлын болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасан цаглабарын дагуу боловсруулж, тайлагнана.”

“2. Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн хагас жилийн болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасан цаглабарын дагуу, нийгмийн даатгалын төв байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабарын дагуу тус тус боловсруулна.

“3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор хянан хэлэлцэж, нийтэд мэдээлнэ.”

Нийгмийн даатгалын тухай хуульд заасан нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг боловсруулж, тайлагнах цагалбарыг 2013 оноос мөрдөж эхэлсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.5-д нийцүүлэв.

(8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

8.9.2.төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.9.5.төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;)



13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг			
7	<p>2. Нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл /зарлагаас давсан орлого/-ийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын зохих дээд шатны байгууллага тухайн төрлийн санд нь улиралд 1 удаа төвлөрүүлж болно. Хэрэв уг үлдэгдлийг дараагийн сар, улиралд шилжүүлэн зарцуулах шаардлагатай бол нийгмийн даатгалын зохих дээд шатны байгууллагын зөвшөөрөл авна.</p>	<p>“4. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл/зарлагаас давсан орлого/-ийг тухайн сан тус бүрийн нийгмийн даатгалын төв байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Тухайн сангийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа сард шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын төв байгууллагаас зөвшөөрөл авна.”</p>	<p>Энэ заалтын дугаар өөрчлөгдсөн, мөн нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг улиралд 1 удаа төвлөрүүлэх заалтыг тухай бүр төвлөрүүлж байхаар зохицуулалт хийсэн.</p>
15 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг			
8	<p>6. Ажлын байрны нөхцөлийн ажиллагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын хүрээнд шийдвэрлэх боломжгүй, түүнчлэн хөдөлмөрийн халуун, газрын доорхи нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтыг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.</p>	<p>“6. Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.”</p>	<p>Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтыг Хөдөлмөрийн болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд хамтран тогтоох тухай өөрчлөлт орсон. Ингэснээр жагсаалтыг үнэн зөв, шуурхай тогтоох, мөрдөх боломжтой боллоо.</p>



9	<p>7. Засгийн газар жил бүр даатгуулагчийн шимтгэл төлөх орлогын дээд хэмжээг Үндэсний статистикийн хорооноос гаргасан дундаж цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэр тус бүрээр ялгавартайгаар тогтооно.</p>	<p>“7. Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно.</p>	<p>Зөвхөн шимтгэл төлөх бус тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар тогтоосноор хуулийг нэг ойлголтой хэрэгжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолттой иргэдээс ирүүлдэг гомдлыг нэг мөр шийдвэрлэх боломжтой боллоо. Мөн шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг ажил олгогчийн хувьд мөрдөхөөр зохицуулсан.</p>
10	<p style="text-align: center;"><b>16 дугаар зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг</b></p> <p>1. Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүрдээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан “нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.</p>	<p>“1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын дансанд шилжүүлнэ.”</p>	<p>Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн сардаа багтаан заавал төлөх ба харин тайлангаа дараа сарын 05-ны дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх зохицуулалтыг тодорхой болгосноор нийгмийн даатгалын сангийн орлого хугацаандаа төвлөрөх боломж бүрдлээ.</p>
11	<p>4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сарын төлөх шимтгэлийг дараа сарын 5-ны дотор төлсөн байна. Шимтгэл төлөх, тайлагнах эцсийн хугацаа нийгмийн даатгалын төрөл бүрт нэг адил байна. Хэрэв энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцвал дараагийн ажлын өдөр шимтгэлийг төлж тайлагнана.</p>	<p>“3. Ажил олгогч нь тухайн сарын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцвал дараагийн ажлын өдөр тайлагнана.”</p>	





	6. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч шимтгэлээ даатгагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрөө төлнө.	“6. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ сар, улирал, хагас жил, жилээр гэрээний дагуу төлнө.”	Малчид, тариаланч, бичил уурхай эрхлэгч, хувиараа бизнес эрхлэгч зэрэг орлого нь тогтворгүй иргэд өөрсдийн орлогын циклд тааруулан сайн дурын даатгалын шимтгэлийг төлөх боломж бүрдлээ.
	<b>12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг</b>		
12	4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар батлагдсан хөрөнгийг Сангийн яам сарын хуваарийн дагуу тухайн сарын эхний 10 хоногт багтаан зохих санд шилжүүлнэ.	“4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар батлагдсан хөрөнгийг Сангийн яам сарын хуваарийн дагуу тухайн сарын эхний 10 хоногт багтаан зохих санд шилжүүлнэ.”	Зөвхөн дугаарлалтын өөрчлөлт оруулсан.
	<b>2<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт</b>		
13	8/ Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд ( хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;	“8/Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;”	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу нэр томъёоны хэсгээс “хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл” гэснийг хассан.



## ХОЁР. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН” ЗААЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

№	ХУУЛИЙН ЗААЛТ		ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ
	Хуучин	Шинэ	
1	<b>16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:</b>		<ul style="list-style-type: none"> <li>• 2 асран хамгаалагч нь даатгуулагч байсан 200 орчим бүтэн өнчин хүүхдэд олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ нэмэгдэж хүүхдийн нийгмийн баталгаа нь сайжирна.</li> </ul>
	ШИНЭ ЗААЛТ	<p>“2. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний 2 тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан 2 даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлсний нийлбэрээс энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр бодож тогтооно.”</p>	
2	<b>22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:</b>		<ul style="list-style-type: none"> <li>• Цалинг нотлох баримтгүйгээс тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг 20 орчим мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр тодорхой хэмжээгээр нэмэгдэх боломж бүрдлээ.</li> <li>• Тэтгэвэр авагчийн орлого нэмэгдсэнээр тэдгээрийн нийгмийн баталгаа сайжрах нөхцлийг бүрдүүллээ.</li> </ul>
	ШИНЭ ЗААЛТ	<p>“4. Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно.”</p>	



3	<b>28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:</b>		<ul style="list-style-type: none"> <li>• 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хууль мөрдөгдөж эхэлснээс хойш Засгийн газар тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний хэмжээг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой уялдуулан хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд зөвхөн нэг удаа;</li> <li>• Тэтгэвэр нэмэгдсэнээр нийгмийн баталгаа сайжрах, тэтгэврийн зөрүү багасах таатай боломжийг энэхүү хуулийн зохицуулал олгож байна.</li> <li>• 1995 оноос өмнө хойно тогтоосон тэтгэврийн зөрүүний талаарх санал гомдол нэг мөр шийдвэрлэгдэнэ.</li> </ul>
	<b>ШИНЭ ЗААЛТ</b>	<p>“2/ Авч байгаа тэтгэврийг нь тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой уялдуулан хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд зөвхөн нэг удаа;”</p>	
4	<b>5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:</b>		<ul style="list-style-type: none"> <li>• 20-иос илүү жил, сар ажилласан даатгуулагчийн шимтгэл төлсөн сарын нэмэгдлийг мөн оруулан тооцох зохицуулалт хийснээр тэтгэвэр нь тодорхой хэмжээгээр нэмэгдэх боломж бүрдэж байна.</li> </ul>
	<p>Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1,5 хувиар бодож нэмэгдэл олгоно.</p>	<p>“2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1,5 хувиар, <b>сар тутамд 0,125 хувиар</b> өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.</p>	



5	<p align="center"><b>12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:</b></p> <p>1. Хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан 16 нас (сургуульд суралцаж байгаа бол 19 нас) хүрээгүй хүүхэд (үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна);</p>	<p>“1/. Хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан <b>19 нас хүрээгүй хүүхэд</b> /үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна/;”</p>	<ul style="list-style-type: none"> <li>• 19 хүртэлх насны хүүхдийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнээр тогтоодог болсноор хүүхдийн эрхийг хамгаалж, даатгалын үйлчилгээг шаардлагагүй баримт бичиг нэхэлгүйгээр түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөл боломж бүрдэнэ.</li> <li>• Сургуульд сурах боломжгүй хүүхэд 19 нас хүртэл тэжээгчээ алдсаны тэтгэвэр авснаар орлогын найдвартай эх үүсвэртэй болж нийгмийн баталгааг нь хангах боломжтой боллоо.</li> </ul>
6	<p align="center"><b>15 дугаар зүйл:</b></p> <p>Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барсан өдрөөс эхлэн хүүхдэд 16 нас ( сургуульд суралцаж байгаа бол 19 нас) хүртэл, тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд нь, тэтгэврийн насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустад олгоно.</p>	<p>“15 дугаар зүйл: Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барсан өдрөөс эхлэн хүүхдэд <b>19 нас хүртэл</b>, тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд нь, тэтгэврийн насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустал олгоно.”</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсэн болон амаржсан даатгуулагч эх хүндэтгэх шалтгаантай бол 6 сарын дотор нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл, холбогдох барим материалыаа бүрдүүлэн өгч тэтгэмж авах боломжийг бүрдүүлж өглөө.</li> <li>• Тэтгэмж авч чадахгүй богино байсан 42 хоногийн хугацааг 180 хоног болгон уртасгав.</li> </ul>
7	<p align="center"><b>24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1 дүгээр заалт:</b></p> <p>Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсан өдрөөс хойш 4 долоо хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах даатгуулагч эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор хүндэтгэх шалтгаантай байсан бол <b>6 долоо хоногийн</b> дотор</p>	<p>Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсан өдрөөс хойш 4 долоо хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах даатгуулагч эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор хүндэтгэх шалтгаантай байсан бол <b>6 сарын</b> дотор</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсэн болон амаржсан даатгуулагч эх хүндэтгэх шалтгаантай бол 6 сарын дотор нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл, холбогдох барим материалыаа бүрдүүлэн өгч тэтгэмж авах боломжийг бүрдүүлж өглөө.</li> <li>• Тэтгэмж авч чадахгүй богино байсан 42 хоногийн хугацааг 180 хоног болгон уртасгав.</li> </ul>



8	<b>26 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:</b>		<ul style="list-style-type: none"> <li>Асрамжийн газарт асруулж тэтгэвэр авагчид тэтгэврийг нь бүрэн олгох болов.</li> </ul>
	Асрамжийн газарт асруулж байгаа тэтгэвэр авагчид урьд тогтоосон тэтгэврийнх нь 30 хувийг олгож болно.	Хүчингүй болсон	
9	28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, /3/ дахь заалтын дугаарыг “3/, 4/” гэж тус тус өөрчилсөн.	28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 2 дахь заалтыг нэмж оруулсан.	Зөвхөн дугаарлалтын өөрчлөлт оруулсан.
10	<b>12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:</b>		<ul style="list-style-type: none"> <li>Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах нөхцлийг хөнгөрүүлж шимтгэлийг нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс 1 жил нь тасралтгүй төлсөн тэжээгч нас барсан бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь түүний шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн авах болмж бүрдлээ.</li> <li>Ингэснээр өнчин хүүхдүүд, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн орлого нэмэгдэж, нийгмийн баталгаа нь хангагдана.</li> </ul>
	Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс сүүлийн 1 жил нь тасралтгүй төлсөн тэжээгч нас барсан бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь түүний шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.	“Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 5-аас доошгүй жил, <b>үүнээс 1 жил нь</b> тасралтгүй төлсөн тэжээгч нас барсан бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь түүний шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.”	


**ГУРАВ. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ЗААЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ**

№	ХУУЛИЙН ЗААЛТ		ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ
	Хуучин	Шинэ	
	<b>2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:</b>		
1	Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэл <b>6</b> сар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.	Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэл <b>12</b> сар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.	<ul style="list-style-type: none"> <li>Ажил олгогч ажилтнуудаа үндэслэлгүй халж, ажилгүйдлийн тэтгэмж авсны дараа буцаан авах зэргээр ажилгүйдлийн санд санаатай хохрол учруулах үйл ажиллагаа багасна.</li> </ul>
	<b>3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:</b>		
2	Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ <b>Засгийн газраас тогтоосон</b> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.	Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ <b>Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос</b> тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.	<ul style="list-style-type: none"> <li>2010 онд батлагдсан “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд нийцүүлэн энэ заалтыг өөрчлөв.</li> </ul>
	<b>4 дүгээр зүйл:</b>		
3	Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг Хөдөлмөрийн хуульд зааснаар ажлаас халагдсаны тэтгэмж авч байгаа бол түүнийг авч дууссаны дараагийн өдрөөс, хэрэв ажлаас халагдсаны тэтгэмж олгогдоогүй бол энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс тус тус эхлэн <b>ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.</b>	Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.	<ul style="list-style-type: none"> <li>Ажилгүй болсон даатгуулагч Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хуульд заасны дагуу тэтгэмж авч байгаа эсэхээс үл хамааран ажилгүйдлийн тэтгэмж авах боломжтой боллоо.</li> <li>Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжийг материал бүрдүүлэн өгсөн өдрөөс эхлэн шууд авах боломж бүрдлээ.</li> </ul>



5 дугаар зүйл:		
4	Ажлаас халагдсан даатгуулагч ажил олгогчтойгоо тооцоо хийж дууссанаас хойш <b>14 хоногийн</b> дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөр эрхлэлтийн албанд, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.	Ажлаас халагдсан даатгуулагч ажил олгогчтойгоо тооцоо хийж дууссанаас хойш <b>14 хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 хүртэл сарын дотор</b> оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөр эрхлэлтийн албанд, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.
6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:		
5	ШИНЭ ЗААЛТ	Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.
7 дугаар зүйл:		
6	Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн алба уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллага сард <b>2 удаа</b> тооцож олгоно.	Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн алба уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллага сард <b>2 хүртэлх</b> хугацаанд тооцож олгоно.
8 дугаар зүйл:		
7	Дараах нөхцөлд даатгуулагчдад олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасна: 1/ өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан; 2/ хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачлагаар ажлаас халагдсан.	Хүчингүй болсон

- Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 14 хоногт амжиж бүртгүүлээгүй даатгуулагч 3 сарын дотор бүртгүүлж, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх тааламжтай зохицуулалтыг бий болголоо.

- Хуульд ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батлах тухай нэмэлт заалтыг оруулав.
- Энэ асуудлыг зохицуулснаар ажилгүйдлийн тэтгэмжийг шуурхай олгох боломтой болов.

- Даатгуулагч сард 2 хувааж авдаг байсан тэтгэмжийг тухайн сардаа бөөнд нь 1 удаа авах боломж бүрдлээ.

- Даатгуулагч ямар шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөнийг үл харгалзан ажлын 76 өдрөөр тооцон ажилгүйдлийн тэтгэмж олгох болсноор ажилгүй байх үеийн орлогын хэмжээ өсөх боломжтой боллоо.



**ДӨРӨВ. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ЗААЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ**

№	ХУУЛИЙН ЗААЛТ		ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ
	Хуучин	Шинэ	
	<b>6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:</b>		
1.	ШИНЭ ЗААЛТ	“3.Тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас 12 сар тутамд 1.5 хувиар бодож нэмэгдүүлэн тогтооно.”	<ul style="list-style-type: none"> <li>• Хуулинд ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчид хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлбөл тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох зохицуулалт орсоноор 1513 тэтгэвэр авагчийн тэтгэвэр тодорхой хэмжээгээр нэмэгдэж, тэдгээрийн нийгмийн баталгаа хангагдах боломжтой боллоо.</li> </ul>
	<b>17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:</b>		
2.	ШИНЭ ЗААЛТ	“5.Үйлдвэрлэлийн осол, мэргэ/жлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйлчилгээнд хамруулах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага батална.”	<ul style="list-style-type: none"> <li>• Тус сангаас тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх чиглэлээр зохион байгуулах ажил тодорхой болно.</li> <li>• Журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажил үр дүнтэй болно.</li> <li>• Тусламж, үйлчилгээний чанар сайжирна.</li> <li>• Хяналт тавих боломж бүрдэнэ.</li> </ul>